ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.18 № 286
танай ____________-ны №______________-т

НАРИЙНТЭЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНД

Хандивын тайлангийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6 дахь заалтад заасны дагуу Төрийн аудитын байгууллага Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Нарийнтээл сумын Монгол ардын намын хорооны ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Нарийнтээл сумын Монгол ардын намын хороо нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6 дахь заалтад заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, мөн хуулийн 16 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

**Хандивын тайлангийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Нарийнтээл сумын Монгол ардын намын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар"-ыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

**Дүгнэлт**

Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Нарийнтээл сумын Монгол ардын намын хорооны иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланд (тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацааны) хандив хүлээн аваагүй байх бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

Нарийнтээл сумын Монгол ардын намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг (..4..хуудас) хавсаргав.

Хувийг: Нарийнтээл сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

Нам. эвслээс ирүүлсэн хандивын
тайлангхянан баталгаажуулж,
дүгнэлт гаргах зааврын хавсралт

МАЯГТ-1

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох
Монгол Ардын намд "ИРГЭН"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

2025.04.14

| Д/д | Иргэний нэр | Хандив өгсөн иргэний мэдээлэл | | | | | | Хандив өгсөн огноо | Хандивын мөнгөн дүн | Хандив хүлээн авсан | | | АНСДИТХ-н сонгуулийн гухай хуулийн 53 4 -т заасан хандивын мэдээллийн шаардлага хангаагүй хандивыг буцаан шилжүүлсэн эсэх | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Иргэний бүртгэлийн дугаар | Нас | Иргэншил | Хандивын эх үүсвэрийн мэдээлэл | Оршин суугаа хаяг | Утасны дугаар | | | Огноо | Банкны нэр | Дансны дугаар | /Тийм, Үгүй/ | Тийм бол мөнгөн дүн | Хандивыг буцаасан дансны дугаар | Буцах хаяг тодорхойгүй хандивыг улсын орлого буюу төрийн санд | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | | | 9 | 10 | 11 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| | | | | | 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | Байхгүй |

Санамж: Аймаг, нийслэл. сум. дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан хугацаанд мөн хуулийн 53, 54. 55 дугаар зүйлд заасан хандивыг хамааруулан дүгнэлт гаргана Харин намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан намын гишүүний өгсөн хандивыг хамруулахгүй болно.

Тамга, тэмдэг

Хянасан:

.......................................................................... / Б. Сугар /

Албан тушаал Овог нэр гарын үсэг

Боловсруулсан:

.......................................................................... /Ц. Батнасан /

Албан тушаал Овог нэр гарын үсэг

Нам. эвслээс ирүүлсэн хандивын
тайланг хянан баталгаажуулж,дүгнэлт
гаргах заавны хавсралт

МАЯГТ-1

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох
Монгол Ардын намд "ХУУЛИЙН ЭТГЭЭД"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

2025.04.14

| Д/д | Иргэний нэр | Хандив өгсөн иргэний мэдээлэл | | | | | | Хандив өгсөн огноо | Хандивын мөнгөн дүн | Хандив хүлээн авсан | | | АНСДИТХ-н сонгуулийн гухай хуулийн 53 4 -т заасан хандивын мэдээллийн шаардлага хангаагүй хандивыг буцаан шилжүүлсэн эсэх | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Иргэний бүртгэлийн дугаар | Нас | Иргэншил | Хандивын эх үүсвэрийн мэдээлэл | Оршин суугаа хаяг | Утасны дугаар | | | Огноо | Банкны нэр | Дансны дугаар | /Тийм, Үгүй/ | Тийм бол мөнгөн дүн | Хандивыг буцаасан дансны дугаар | Буцах хаяг тодорхойгүй хандивыг улсын орлого буюу төрийн санд | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | | | 9 | 10 | 11 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| | | | | | 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | Байхгүй |

Санамж: Аймаг, нийслэл. сум. дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан хугацаанд мөн хуулийн 53, 54. 55 дугаар зүйлд заасан хандивыг хамааруулан дүгнэлт гаргана Харин намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан намын гишүүний өгсөн хандивыг хамруулахгүй болно.

Тамга, тэмдэг

Хянасан:

........................................................................ / Б. Сугар /
Албан тушаал Овог нэр гарын үсэг

Боловсруулсан:

........................................................................ /Ц. Батнасан /
Албан тушаал Овог нэр гарын үсэг